



**МОНГОЛ УЛСЫН
ШИНЖЛЭХ УХААНЫ АКАДЕМИ**

**ОРЧЛОН ЕРТӨНЦИЙН ТУХАЙ
ХҮМҮНИЙ УХААРЛЫН
ДҮР ЗУРАГ**

Шинин мэдэхүйн цуврал-10

**Улаанбаатар хот
2015 он**

ГАРЧИГ

Ертөнцийн тухай шашны ба шинжлэх ухааны дүр зураг	2
Ертөнцийн дүр зураг.....	3
Ертөнцийн тухай шинжлэх ухааны сонгодог дүр зураг нь.....	11
Ньютоны физикийн гурван хууль	13
Сонгодог сонгодог <i>бус</i>	21
Онтологи онтологи	21
Субъектив объектив	22
Амьдралын философи	23
Экзистенциалист философи	24
Психоаналитик философи ба структурализм	24
Ном зүй.....	27

ЕРТӨНЦИЙН ТУХАЙ ШАШНЫ БА ШИНЖЛЭХ УХААНЫ ДҮР ЗУРАГ

Та бидний танин мэдэхүйд хязгаар тавьж болдоггүй. Тэгэхлээр орчлон хорвоогийн тухай бидний ойлголт төсөөлөл ч бас л хязгааргүй юм. Энэ хязгааргүйд тасралтгүй үргэлжлэх оюуны үйл явцыг бид хүн төрөлхтний сэтгэлгээний түүх гэж нэрлэдэг.

Сэтгэлгээний энэ түүхэнд орчлон ертөнцийн тухай домгийн, шашины, философийн, байгалийн шинжлэх ухааны гэх мэт янз бүрийн дүр зураг бүтээгдсэн, одоо ч бүтээгдсээр байгаа юм. Тэдгээрийг хамгийн ерөнхий байдлаар шашины ба шинжлэх ухааны гэж ялгаж болно. Хүн орчин тойрныхоо юмс үзэгдлээс эхлээд орчлон ертөнц яаж үүссэн, хэрхэн хөгждөг тухай бодож эргэцүүлж эхэлсэн тэр эртний үеэс л анхны сүсэг бишрэлийн хэл бэрүүд үүссэн байна. Сүсэг бишрэлийн анхны хэлбэрүүдээс үндэсний болон дэлхийн томоохон шашнууд бий болжээ. Аль ч шашин сүсэг бишрэлд үндэслэсэн ертөнцийн дүр зургийг гаргаж байв. Тэр дүр зураг түүхийн эрин үе бүрд өөрчлөгдсөөр эдүгээ ч үргэлжилж байна. Хүмүүс тодорхой баримт нотолгоо, хэмжилт тооцоо, судалгаа туршилтын дүнд орчлон ертөнцийн тухай дүр зураг гаргах болсноор шинжлэх ухаан үүсч хөгжсөн байна. Шинжлэх ухааны ийм дүр зураг бас л түүхэн хөгжлийн явцаар өөрчлөгдсөөр иржээ. Шинжлэх ухаан өндөр хөгжсөн одоо үед ч орчлон ертөнцийн тухай төгс төгөлдөр дүр зургийг бүтээж чадаагүй байна

. Ер нь ертөнцийн дүр зураг гэж юу вэ?

Ертөнцийн дүр зураг хэрхэн бүтээгддэг вэ?

Ертөнцийн дүр зурагт юу юу багтдаг вэ?

Ертөнцийн дүр зураг гэдэг бол хүний танин мэдэхүйн

Орчлон ертөнцийн тухай хүмүүний ухаарлын дүр зураг

явцад ертөнцийн үүсэл, хөгжих хууль, зүй тогтол, бүтэц байгууламж, ертөнцөд хүн, хүний нийгмийн эзлэх байр суурь, үүрэг, зорилго, утга учир зэргийн талаар буй болсон нэгдмэл үзэл, цогц төсөөлөл юм.

ЕРТӨНЦИЙН ДҮР ЗУРАГ

Орон зайн хязгаартай хязгааргүйн тухай, цаг хугацааны мөнх ба мөнх бус, эхлэл ба төгсгөлийн талаарх	Цаг хугацаа, орон зайд орших объектуудын янз бүрийн дүр төрх, бүтэц зохион байгуулалт, харилцан үйлчлэлийн талаарх системтэй төсөөлөл
ТӨСӨӨЛӨЛ Шк Хүний мөх чанар ба түүний ертөнцөд эзлэх	
Ертөнцийн бүхий л элемент, объектуудыг зохицуулдаг ерөнхий хууль, зүй тогтлын тухай төсөөлөл	Ертөнцөд болж өнгөрч буй үйл явцын зорилго, утга учрын талаарх төсөөлөл

Хүн төрөлхтний соёл иргэншлийн түүхэн үе шат бүрт ертөнцийн талаарх тодорхой дүр зураг ноёрхож иржээ. Тухайлбал, хүн төрөлхтний түүхийн балар эртний үед хамаарах домгийн, дундад зууны үед ноёрхож байсан шашны, сэргэн мандалтын үеэс эхэлсэн шинжлэх ухааны гэсэн ертөнцийн дүр зургуудыг онцолж болно.

Хүн төрөлхтний танин мэдэхүй буюу ухаарлын явцад бий болсон ертөнцийн эдгээр дүр зураг бүр өөр өөрийн онцдогтой.

Домгийн дүр зураг. Ертөнцийн тухай домгийн дүр зураг бол сэтгэлгээний түүхийн хамгийн эртнийх юм. Ертөнцийн амьд бүхэн сэтгэл зүрхтэй, ертөнцөд оршин буй бүхэн сэтгэл зүрхний хүч, хууль зүй тогтолд захирагддаг. Хэрэв эдгээр хуулийг зөрчих юм бол маш аюултай хор уршигтай учрах болдог. Жишээ нь, модыг тайрахаасаа өмнө уучлал гуйж залбирал үйлдэх, ан гөрөө хийхдээ уул усандаа мөргөж хишиг буянаа хайрлахыг гуйх гэх мэт.

Орчлон ертөнцийн тухай хүмүний ухаарлын дүр зураг

Монголчуудын дунд өнөөг хүртэл хадгалагдаж байгаа нэгэн заншил болуулусаа аргадаж, бороохур оруулахын тулд



овоо тахих ёс юм. Овоо тахисны дараа тэнгэр дуугарч бороо ордог гэдэгт нийтээрээ итгэдэг. Энэ нь монголчуудын хун байгалийн харилцан шүтэлцээтэй оршдогт үндэслэсэн дотгийн дүр зураг юлг.

Ертөнцийн тухай домгийн дүр зурагт том ертөнцөд багтах олон тооны жижиг ертөнц үүсч байдаг. Эдгээр тус тусдаа ертөнц нь өөрийн гэсэн орон зай, цаг хугацаатай, өвөрмөц зүй тогтол, жам ёстой гэж үздэг. Хүний амьдрал бол энэ жам ёсыг зөрчдөг аймшигтай, хачирхалтай, далдын хүчнүүдийн эсрэг амьд үлдэхийн төлөөх тэмцэл юм. Амьдрал бол бүх ертөнцийн хууль-хувь заяанд захирагдах янз бүрийн оршигч зүйлсийн өөрийн зорилгод хүрэх гэж оролдож буй тэмцэл тулааны талбар билээ.

Монгол угсаатны дунд эрт дээр үеэс тархсан Гэсэр, Жангарын туульд гол баатрууд лгуу хорон санаатай хучнуудтэй тулалдаж, ялж дийлж байгаа үзэгдлүүд элбэг байдаг. Энд хуний оршихуйн утга учир нь өөрийн болон олон тутний хувь заяаныхаа ирээдүйн төлөө тэлгцэж илүү их гавъяа байгуулах нь гол зорилго болдог.



Домгийн сэтгэлгээн дэх бүх ертөнцийн хууль бурхдыг ч хүртэл багтаах бөгөөд тэд бүхнийг чадагч биш юм. Бурхдыг хуурч бас түлхэн унагаж, устгаж болно. Ертөнцийн домгийн дүр зураг нь нэгдмэл чанартай бөгөөд энд ердийн ба ер бусын ертөнц нэгдэн нийлж байдаг. Домог төрсөн

Орчлон ертөнцийн тухай хутушийг ухаарлын дүр зураг

тэр үед байсан шашны бурхад нь далдын ид шидтэй хүч юм. Энд яригдаж буй бурхад бол нэг талаас, шашны, нөгөө талаас, домгийн сэтгэлгээний бүтээл билээ.

Домгийн сэтгэлгээн дэх бүх ертөнцийн хууль бурхдыг ч хүртэл багтаах бөгөөд тэд бүхнийг чадагч биш юм. Бурхдыгхуурч бас түлхэн унагаж, устгаж болно. Ертөнцийн домгийн дүр зураг нь нэгдмэл чанартай бөгөөд энд ердийн ба ер бусын ертөнц нэгдэн нийлж байдаг. Домог төрсөн тэр үед байсан шашны бурхад нь далдын ид шидтэй хүч юм. Энд яригдаж буй бурхад бол нэг талаас, шашны, нөгөө талаас, домгийн сэтгэлгээний бүтээл билээ.

Ертөнцийн тухай домгийн дүр зураг бол орон зай, цаг хугацааны тодорхой хэмжүүрт хүн, байгаль, бурхад гурвын нэгдэж харьцах харилцаа юм.

Монгол угсаатны дунд эрт дээр үеэс тархсан Гэсэр, Жангарын туульд гол баатрууд муу хорон санаатай хучнуудтэй тулалдаж, ялж дийлж байгаа үзэгдлүүд элбэг байдаг. Энд хуний оршихуйн утга учир нь өөрийн болон олон түлгний хувь заяаныхаа ирээдүйн төлөө тэлгцэж илүү их гавъяа байгуулах нь гол зорилго болдог.



Ертөнцийн духай домгийн дүр зургийн бүдүүвч



Орчлон ертөнцийн тухай хүмүний ухаарлын дүр зураг

Шашны дүр зураг. Ертөнцийн тухай шашны дүр зураг нь ямар нэг бүхнийг чадагч, бүхнээс хүчтэй, мөнхийн, үнэмлэхүй эрх бүхий далдын ид шидэт хүчний тухай / Тэнгэр бурхан, Ертөнцийн эзэн, Аллаx тэнгэр гэх мэт/ төсөөлөл байдаг. Ертөнцийн тухай шашны ямар ч дүр зургийн гол бүтээгч хүч бол нэг эсвэл олон бурхан байдаг. Тиймээс ертөнцийн тухай аль ч шашны дүр зургийн онцлог нь бодит байдлыг: ерийн буюу ертөнцийн амьдрал, ер бусын буюу далдын хүчний зохицуулалт хэмээн ялгаж далдын хүчний ид шидийг чухалчилдаг.

Бурхан буюу далдын хүч нь хүн, ертөнц, цаг хугацаа, орон зайг бүтээсэн гэнэ. Хүмүүс бурхадтай харьцаж болно. Ингэж харьцахдаа оюун ухаан, мэддэгийн хүчээр бус, харин сүсэг бишрэл, итгэл үнэмшлээрээ дамждаг. Шашны ухаарлаар бол ертөнц цаг хугацаа ба орон зайн хувьд эхлэлтэй, бас төгсгөлтөй юм.

Ертөнцийн түүх нь Бурхнаас холдож эсвэл ойртсон чиглэлтэй байдаг. Хүнийг Бурхны дүртэй адил бүтээсэн ба хүн нь ертөнцийн төвд оршдог юм.

Хүнээс дээр оршдог нь бурхдууд, доор оршдог нь амьтад юм. Ертөнцийн бүхий л хууль Бурхны хүсэл зоригийн илэрхийлэл байна. Хүний амьдралын утга учир нь Бурхны хүсэл зоригийг чөлөөтөй хүлээн авахад оршиж байдаг. Шашин тодорхой философитой. Ийм философи дундад зуунд их хүчтэй хөгжжээ. Дундад зууны философич Аквины Фома¹ ахуй хэмээх ойлголтоор ертөнцийг бүтээсэн бурхныг илэрхийлсэн байдаг. Тэрээр мөн чанар гэдэг ойлголтыг бас хэрэглэсэн.

Мөн чанар бол юмс үзэгддийн энгийн шинж чанараас ялгаатай бие даасан ахуй юм. Харин аливаа юмны шинж чанар зөвхөн мөн чанарын ачаар л оршдог.

Аквины Фома ахуй ба мөн чанар хоёр эсрэг тэсрэг биш

1Аквины Фома (1225-1274) нь дундад зууны схоластик философийн гол төлөөлөгч юм.

Орчлон ертөнцийн тухай хутуний ухаарлын дүр зураг болохыг Аристотелийн сургаалд тулгуурлан баталжээ. Түүнийхээр бурхан² бол мөн чанар, харин хүн, хүний ертөнц нь шинж чанар юм.



Шашин бүрийн ертөнцийн дүр зураг нь сургаал номлолынхоо агуулгаас хамаарч өөр өөрийн онцдог шинжтэй. Тухайлбал, ертөнцийн тухай христ, ислам, буддын шашны дүр зураг нь хоорондоо ялгаатай байдаг.

Христийн шашинд орчлон ертөнц бол ертөнцийн эзний /бурхан/ бүтээл гэдэг. Исус Христ бол ертөнцийн эзнийг хүн төрөлхтөнтэй холбогч илч. Шинэ гэрээ бол хэрхэн холбох тухай сургаал номлол. Ингэхээр хүн төрөлхтний түүх бол дээд сайн сайхан, буян, зохицолд хүрэх, ертөнцийг бурхантай холбох үйл явц болдог.

Исламын шашинд орчлон ертөнц бол Аллах тэнгэрийн тааллаар бүтээгдсэн зүйл. Мухаммед бол түүний хүн төрөлхтөнд илгээсэн илч. Куран судар нь Аллах тэнгэрийн тааллыг хүнд төрөлхтөнд номлосон сургаалын цогц. Тэгэхээр хүн төрөлхтний түүх бол Аллахын таалал хэрэгжих үйл явц юм.

Буддын шашинд зургаан галав² гэсэн сансрын цаг

²Галав гэдэг нь цаг хугацаа орон зай, агуулгын хэтжуур бүхий сансар огторгуйг илэрхийлнэ. Ертөнцийн ууслийн утгаараа галав гэдэг нь дөнгөж уусэж байгаа ертөнц нөгөө талаас газар дэлхийг өөрөөсөө уусгэсэн этх затбараагүй төлөв болдог байна.

Орчлон ертөнцийн тухай хүмүний ухаарлын дүр зураг

хугацааны ойлголт байдаг. Үүнд тогтох, орших, эвдрэх хоосон гэсэн бага галав буюу тэдгээр тус бүрт мөн 20 галав байх бөгөөд эдгээр нийт засврын 80 галавыг их галав хэмээдэг. Галав бүрийг дамжин ертөнцийн түүх бүтээгддэг. Энд бурхад гол үүрэг гүйцэтгэнэ. Буддын шашны бурхад бол төгс гэгээрэлд хүрсэн хүний хойт дүр юм.

Буддын шашинд ертөнцийг бурхан бүтээсэн бус харин ертөнцийн хамаг юм хоорондоо пгүтэн барилдаж үүсдэг бөгөөд амьдрап нь үйлийн үрийн тойрог болох сансар хорвоод оршдог. Үүнийг Сансарын хүрдний дүрслэлээр илэрхийлдэг.

Буддын шашинд ертөнцийг бурхан бүтээсэн бус харин ертөнцийн хамаг юм хоорондоо шүтэн барилдаж үүсдэг бөгөөд амьдрал нь үйлийн үрийн тойрог болох сансар хорвоод оршдог. Үүнийг Сансарын хүрдний дүрслэлээр илэрхийлдэг.

Сансарын хүрд



Дэлхийн гурван том шашнаас гадна үндэстэн угсаатны олон

Орчлон ертөнцийн тухай хүмүний ухаарлын дүр зураг арван шашин бий. Тэдгээрийг гол шүтээн, зан үйл нь ялгаатай боловч ертөнцийн тухай дүр зураг нь ерөнхий агуулгаар дээрх шашнуудтай ойролцоо байдаг. Дүгнэж хэлбэл, ертөнцийн тухай шашны дүр зургийг ерөнхий шинжээр нь дараах байдлаар илэрхийлж болно.


Ертөнцийн духай шашны дүр зураг



Шинжлэх ухааны дүр зураг. Ертөнцийн тухай шинжлэх ухааны дүр зураг сэргэн мандалтын үед бий болж, цэгцэрч эхэлсэн гэж үздэг. Чухам энэ үед хүн ертөнцийг бүтээгч мөн гэсэн санааг Н.Кузанский³ Фичино болон Пико Делла Мерандолла нар дэвшүүлж байлаа. Мөн энэ үед Коперник (1473-1543) дэлхий өөрийн тэнхлэгээ эргэдэг, дэлхий нарыг тойрдог, нар ертөнцийн төв юм хэмээх алдарт нээлтээ хийжээ. Үүний үр дүнд орчлон ертөнцийн тухай дэлхий төвт үзэл няцаагдаж, гариг эрхэс, орчлон ертөнцийн тухай нар төвт тогтолцоонд суурилсан шинжлэх ухааны дүр зураг бүтээгдсэн юм.

³Николай Кузанский (1401-1464) сэргэн мандалтын үеийн сэтгэгч.

Орчлон ертөнцийн тухай хүмүний ухаарлын дүр зураг



Сэргэн мандалтын үед орчлон ертөнцийн дүр зураг төдийгүй хүн, нийгмийн тухай үзэл ч гэсэн өөрчлөгдөж, хүн өөрөө өөртөө эзэн, хүний нийгмийн түүхийг бүтээгч хэмээх хүн төвт үзэл дэлгэрчээ. Хүн бүхнийг бүтээгч болсон учраас энэ дэлхий дээр төгс нийгмийг байгуулах боломжтой тухай утоп үзэл* санаа ч хөгжив. Хүн хувь заяаныхаа эзэн, нийгэм, соёл иргэншлийн түүхийг бүтээгч, оршин буйг өөрчлөн сайжруулж, эрх чөлөөтэй амьдрах ёстой гэх үзэл санааны далбаан дор тухайн үеийн европ дахинд хувьсгалт үйл явц өрнөж эхлэв.



* Упот үзэл гэдэг нь төгс нийгмийн тухай үзэл бөгөөд гол бүтээл нь Томас Морын “Утоп арал”, Кампанелла “Наран хот” юм.

Орчлон ертөнцийн тухай хутуний ухаарлын дүр зураг

Франц, Англи, Герман зэрэг орнуудад эхэлсэн хувьсгалууд европ тивийг хамран өргөжиж, дэлхий ертөнцийн нийгэм, соёл иргэншлийн дүр зургийг цоо шинээр бүтээсэн байна.

Ийнхүү орчлон ертөнцийн оршин байхуйн уг чанар, нийгэм, соёл иргэншлийн жам ёс, хүний мөн чанар хувь заяаны олон асуудлыг хамарсан ертөнцийн тухай хүмүний ухаарлын шинэ дүр зураг сэргэн манддын үед бүтээгджээ.

ертөнчинн дүр \$ураг

Сансар огторгуй

Байгаль

Нийгэм



Бурхан

Ертөнцийн тухай шинжлэх ухааны сонгодог дүр зураг нь XVII-XVIII зууны үед сонгодог механик электродинамикийн хуульд тулгуурлан бүрэлдэн тогтжээ. Түүний үндэс нь үнэмлэхүй цаг хугацаа орон зайны тухай төсөөлөл юм. Цаг хугацаа орон зайны жижиг үл хуваагдах хэсгүүд-атомоос бүтэх бодит биетүүд оршино. Атомууд нь мөнх оршдог, тодорхой хууль, зүй тогтлын дагуу хоосон орон зайд (үүнийг хөдөлгөөний тухай Ньютоны физикийн гурван хууль илэрхийлдэг) бүх хөдөлгөөнийг удирддаг тухай байгалийн шинжлэлийн шинэ нээлтүүд гарав.

Орчлон ертөнцийн тухай хүмүүний ухаарлын дүр зураг



Цахилгаан гүйдэл гэдэг нь цэнэгүүдийн хөдөлгөөн юм. Тодорхой бодисуудад ялангуяа металлд электронууд маш хялбар хөдлөх боломжтой байдаг. Электрон нь цэнэгтэй учраас электроны урсгал нь цахилгаан гүйдлийн урсгал гэсэн үг болно.

Энэ үед аливаа өөрчлөлт хөдөлгөөн нь өөрийн шалтгаантай, харин тохиолдол нь танин мэдэж амжаагүй хууль зүй тогтол юм гэсэн шинжлэх ухааны үзэл ноёрхож байлаа. Энэ үзлийн гол агуулгыг физикийн тулгуур хуулиуд тодорхойлж байв. Хүний үйлдэл нь эцсийн эцэст физик бодит зүйлсийн хууль, зүй тогтлын илэрхийлэл юм. Хүн ч, нийгэм ч байгалийн нэг л хэсэг юм. Хүний оюун ухаан, мэдрэмж, сэтгэлгээний мөн чанар бол уг чанартаа мэдрэлийн тогтолцооны цахилгаан долгионтой адил. Түүх, хүний амьдрал, байгальд ямар нэг зорилго байхгүй, харин эдгээрийг үл өөрчлөгдөх мөнхийн хууль зүй тогтол л захирч байдаг.

Орчлон ертөнцийн тухай хүмүүний ухаарлын дүр зураг

Ньютоны физикийн гурван хууль

Нэгдүгээр
хууль

• Алваа биед гадны дгүч үйлчлэхгүй бол тайван байсан бие тайван хэвээрээ, хөдөлгөөнд байсан бие хөдөлгөөнд хэвээр үлдэнэ. Ньютоны 1-р хууль битүү системд хүчинтэй. Ямарч хүч байхгүй системьг битүү систем гэнэ.

Хоёрдугаар
хууль

• T масстай биед F хүчээр үйлчлэхэд a хурдатгалыг олж авдаг. (Хүч хурдатгал 2 нэг чиглэлтэй) хүчийг үйлчилсэн хугацаагаар нь үржүүлснийг импульс гэнэ.

Гуравдугаар
хууль

• Аливаа бие хоёр дахь биед F хүчээр үйлчлэхэд хоёр дахь бие нь эхний биед $-F$ хүчээр үйлчилнэ. F ба $-F$ нь ижил хэмжээтэй бөгөөд эсрэг чиглэлтэй.

Шинжлэх ухааны хоёр дахь хувьсгал нь XIX-XX зууны физикийн шинжлэх ухааны нээлтүүдтэй холбоотой байлаа. Үүний үр дүнд орчлон ертөнцийн тухай шинжлэх ухааны цоо шинэ дүр зураг бүтээгдсэн байна.


Эйнштейний* харьцангуйн онол гарч цаг хугацаа ба орон зайн (огторгуйн) бүтэц мөн түүнчлэн Таталцдын (Гравитацийн) тсптмолыг нээснээр шинжлэх ухааны шинэ шинэ онол төрөн гарах боломж бүрдэв. Эдгээр онолууд нь харьцангуйн тусгай ба ерөнхий гэсэн хоёр ангилалд хувааж болох физикийн онолуудаас бүрддэг.

Харьцангуйн тусгай онол бол бие биеийнхээ хувьд харьцангуйгаар хөдөлж байгаа ажиглагчдын өнцгөөс, цаг хугацаа ба орон зайн харьцаа болон түүнтэй холбоотой үзэгдлүүдийг тодорхойлдог. Онолын энэ үндэслэл дээр суурилан массаас шалтгаалан орон зай ба цаг хугацааны муруйлтаас таталцал үүсдэг гэсэн харьцангуйн ерөнхий онол гарчээ.

*Льберт Эйнштейн (1879-1955) нь Германы онолын физикч.

Орчлон ертөнцийн тухай хүмүүний ухаарлын дүр зураг

Үүнийг хялбаршуулан тайлбарлая. Орон зай, цаг хугацааг хавтгай боловч дотогшоо сунаж тэлдэг гудас мэт зүйлсээр төлөөлүүлье. Тэгээд хавтгайн голд нь хүнд төмөр бөмбөлөг тавьбал тэрээр доошоо шигдэн эргэн тойрныхоо хавьд хонхойж хотойсон хэлбэр үүсгэх болно. Хэрвээ гудсан дээгүүр хөнгөн бөмбөг өнхрүүлбэл зүгээр өнхөрч одох болно. Харин хүнд жинтэй зүйлс, тухайлбал нар (төмөр бөмбөлөг) орон зайд (гудсанд) нөлөө үзүүлж хэлбэрийг нь өөрчлөн сунгаж муруйлган, үүнээс болж гудасны хонхорхойд ойрхон зүйлс хонхорхой руу татагдан гулсах болно. Үүнийг дээр дурьдсан харьцангуйн тусгай болон ерөнхий онолд таталцлын хүч буюу орон зайн муруйлт гэдэг байна.



Ийнхүү цаг хугацаа, орон зай нь материаллаг объектоос (биетийн цаг хугацаа орон зайн шинж чанар нь түүний яаж хөдөлж байгаагаас шалтгаалдаг гэсэн үг) хэрхэн хамааралтай, эдгээрийн хоорондын хамаарлын тухай харьцангуй цаг хугацаа, орон зайн тухай ойлголт бий болж байна. Өөрөөр хэлбэл, орон зай цаг хугацаа хувьсамтгай хэмжигдэхүүн болсон бөгөөд бие хөдөлж эсвэл хүч үйлчилж байхдаа орон зайн муруйлт, цаг хугацаанд нөлөөлж, орон цагийн бүтэц нь бие хэрхэн ходолж, хүч яаж үйлчлэхэд эргээд нөлөөлдөг байна.

Орчлон ертөнцийн тухай хүмүүний ухаарлын дүр зураг

Орон зай, цаг хугацаа хоёр орчлон ертөнцөд болж байгаа бүхэнд нөлөөлдөг төдийгүй, өөрсдөө ч түүний хүрээнд болж байгаа бүхний нөлөөнд ордог байна. Хэрэв цаг хугацаа, орон зай нь хөдөлж буй материйн шинж чанараас хамаардаг бол эндээс янз бүрийн космологийн загвар гарах боломжтой гэдгийг харуулж байна.


XX зууны физикийн шинжлэх ухаанд Эйнштейний харьцангуй онол дээр үндэслэсэн, Хаббл*, Фридманы** харьцангуй, хаалттай сансар огторгуйн загвар бүрэлдэн тогтжээ.

Хабблын ажиглалтаас өмнө орчлонд оршин буй галактикийн тоог ердөө ганцхан гэж үзэж байсан. Тэр нь тэнгэрийн заадал.



1924 онд Хаббл орчлонд ганцхан галактик бус харин маш олон өөр бүсэд бие даасан галактикууд байгааг хэлсэн байна. Тэрээр орчлон өөрөө хэр том бэ гэсэн асуултдаа хариулт олохын тулд галактикуудын спектрийг хэмжсэн байна.

Хабблын дуран



* Эдвин Хаббл (1889—1953) — америкийн одон орон суддаач ** А.А. Фридман (1888-1925) — оросын математикч, физикч.

Орчлон ертөнцийн тухай хүмүүний ухаарлын дүр зураг

Үүний үр дүнгээр 1930-аад онд тэрээр сансар дахь галактикууд биднээс улам бүр холдож байгааг илрүүлжээ. Галактикууд хэдий чинээ хол байна төдий чинээ хурдтай нүүж, орчлон асар хурдтайгаар зүг бүр тийш тэлж байв. «Эмх замбараагүй тэлэх ертөнц»-ийн тухай онолыг (АДЛинде, 1983) релятивист космологийн шинэхэн хөгжил хэмээн үнэлдэг. Энэ талаар Линде бичихдээ «Тэлж буй ертөнцийн глобаль бүтцийн үндсэн онцдог нь нөхцөлт ДҮР зураг юм. Тэлж буй ертөнцийн нэг хүрээ нь олон шинэ хүрээг бий болгодог. Тэгээд бас эгэл хэсгүүдийн харилцан үйлчлэлийн хууль болон цаг хугацаа, орон зайны шинж нь янз бүрийн хүрээнд өөр өөр байж болдог. Хүрээгээ улам тэлж буй Орчлон ертөнц нь бүхэл болохыноо хувьд төгсгөл, эхлэлгүй юм» гэсэн байна.

Үүгээр орчлон ертөнцийн нэгдмэл загвар үгүй болж, харин янз бүрийн орон зай-даг хугацааны «хөөсөнцөр»-т тохирох тусгаар төсгөлгүй олонлог загваруудын тухай үзэл ноёрхох болов.

Тэлж буй сансрын загвар



Метагалактикийн орон зай нь тогтмол, эерэг, муруй бүхий евклидын бус орон зай мөн. Үүнийг физикт Фридманн

Орчлом ертөнцийн тухай ху.нуний ухшфлын дүр зураг хаадттай загваргэж н*иидл\ Ийм мурун орон <айн статнк бус шинж нь мурунн радиусын хэмжээ цаг хушцаанаас хамаарна гэдэг. 1 лар хугацаа өнгөрохөд радиус нь нэмэгдэж орон зай тэддэг. Ертөнцийн тэлэх онолын год үндэслэлүүд нйм юм.

Мстагалактмк



Сонгодог физик нь орон зайг төлхтөлгүй. цаг хугацааг зхлэлгүй х >мэл үздэг бол харин дээр дурдсан Фридманы хаалттай сансрын загвар нь цдг хугацаа орон тай нь твгсголөг шинжтэй юм гэж баталдаг. Үүнийг зурагт дараах бандлаар харуулж байна.





Дурын материаллаг тогтолцооны жам ёсны шинж нь арай бага тогтвортойгоос их тогтвортой руу шилжих, эцсийн дүндээ

Энэ бүхэн ертөнцийн шинжлэх ухааны шинэ дүр зургийг бүтээх чухал үндэслэлүүд болж байгаа билээ.

Орчлон ертөнцийн тухай хүмүүний ухаарлын дүр зура.

**XX зуунаас XXI зуунд шилжих тэр үед нанотехнологи гэгдэх нэр толгъёо ууссэн байна. Нано гэдэг 10-ийн хасах 9 зэрэгт буюу 10^{-9} гэсэн утгатай бөгөөд нанотехнологит нанотетр (нм) хэтээх хэмжээс гол нэгж нь болдог. Тэгвэл нэг атолын хэлгжээ лгаань 0.1 нм байдаг. Нанотехнологи гэдэг бол аливааг нано хэлгжээст туйшинд угсрах, бүтээх, өөрчлөх технологи. Нанотехнологи гэдэг нь нэг эс болгоныг хавчаараар хавчин эвлүүлж, янз бүрийн дарааллаар байрлуулснаар, олон төрлийн шинж чанартай бодис болон материалыг уусгах шинжлэх ухаан гэсэн уг юлг.*



Ертөнцийн тухай домгийн, шашны, шинжлэх ухааныхаас гадна философийн дүр зураг гэж бий. Философи нь юуны өмнө түгээмэл ийн тухай ухаан учраас ертөнцийн дүр зургийг түгээмэлийн төвшинд, язгуур уг чанар, оршихуйн жам ёсны хүрээнд бүтээдгээрээ онцдог. Ертөнцийн тухай философийн дүр зураг онолын үзэл санааны тогтолцоонд тулгуурладаг ба ертөнцийг эмх цэгц бүхий бүхэл зүйл хэмээн үзэж улмаар хүн ба орчлон ертөнцийн харилцаа холбоог ойлгох түвшинд хүрсэн байдаг. Философи нь хүн төрөлхтний сэтгэлгээний ололтыг илэрхийлсэн олон дэг сургууль, чиглэлийг багтаадаг. Жишээ нь, оршихуйн тухай санаалаг, материаллаг, эмпирик ба рациональ, сансар төвтөй ба бурхан төвтөй зэрэг ертөнцийн тухай философийн олон дүр

Орчлон ертөнцийн тухай хүмүүний ухаарлын дүр зураг

зургийг ярьж болно.

Философи нь ертөнцийн тухай домгийн дүр зураг уналтад орох үед үүсэн бий болж, улмаар ертөнцийн тухай шинжлэх ухааны дүр зургийн хөгжилд чухал нөлөө үзүүлсэн байна. Мөн ертөнцийн тухай шинжлэх ухааны ДҮР зургийн агуулгын өөрчлөлт философийн хөгжилд бас нөлөөлдөг юм. Үүний тодорхой жишээ бол ХЕХ зууны сүүл, ХХ зууны эхэн үеийн байгалийн шинжлэх ухааны хямралын философид үзүүлсэн нөлөө мөн. ХХ зууны философийн онтологи болон танин мэдэхүйн томоохон эргэлтүүд нь мөн л ертөнцийн тухай хүний үзэл, үнэлэмж өөрчлөгдөх боломжийг бүрдүүлсэн юм. Тухайлбал, Хайдеггериин суурь онтологи нь “дазайн” хэмээх ойлголтоороо хүний оршихуйг анхдагч, суурь шинжтэй болохыг үндэслэж, хүний ахуй нь зөвхөн бодит ертөнцийг төдийгүй боломжит ертөнцийг ч багтаадаг тухай үндэслэл дэвшүүлснээрээ ертөнцийн тухай хүний үзэл төсөөлөл өөрчлөгдөх нэг нөхцлийг бүрдүүлжээ.

ХХ зууны онтологид гарсан эргэлт



Сонгодог онтологи

Сонгодог *бус* онтологи

Ертөнцийн тухай философийн ба шинжлэх ухааны дүр зураг бүрэлдэн тогтох логик, зарчим нь нэг үндэстэй болохыг энэ эргэлтээс харж болно. Тиймээс ертөнцийн тухай шинжлэх ухааны ба философийн дүр зураг, ялангуяа танин мэдэхүйн арга нь бие биеэ нөхөн гүйцээдэг. Философийн мэдлэг нь аль нэгэн агшин, тодорхой цаг үед шинжлэх ухаан, шашны дэвшүүлж байгаа ертөнцийн тухай дүр зургийг хамгийн төгс төгөлдөр эцсийн үнэн

Орчлон ертөнцийн тухай хүмүүний ухаарлын дүр зураг

хэмээн дутуу бодож туйлширахаас ямагт урьдчилан сэргийлэх билээ.

Ертөнцийн тухай философийн дүр зургийн ерөнхий шинж бол ертөнцийг бүхэл байдлаар харахыг эрмэлздэг оюунлаг чанар мөн. Үүний зэрэгцээ философийн олон янзын дүр зураг нь хүн-ертөнцийн харилцаанм хүрээнд бүрэлдэж тогтдог. Тэгэхлээр хүнийг бүрэн сайн таньж мэдье гэвэл орчлон хэмээх бүхэллэг тогтолцооны бүтэц, хувьслын зүй тогтлыг судалж ойлгох хэрэгтэй болно. Үүний үр дүнд бид орчлонгийн бүтэц тогтолцоонд хүний эзлэх байр суурийг шинжлэх ухааны үндэстэй олж мэдэх боломжтой.

Ертөнцийн тухай философийн дүр зургийг ерөнхийд нь хоёр ангилж болно.

ё к ъ л ь г с з л ь ц ө ь s
Ө ө ї нь й нь Ө ө с з л ь ё к
г ц к ь я

й " - ₣ = " ' , - нь - ₣ = " ' , -

Ÿ „ - > € † _ _ ... , ' † — € % € †
_ ... ' † !! , „ > - „ % _ ... € † - ‡ — , '
_ - - ' _ - „ ' / _ ' _ - - _ - _ -
† € † % ‡ „ ₣ = „ ' , -
/ , † ' ' € ' . ө † _ _ ... , ' †
‡ ... / , > " ' † † _ > !! ‡ "
- - ' _ - - - - - ... - - - - - > ‡ —
— - † !! - - - - - _ - - - -
ё ... ' _ † !! , ' — ' - † , † „ € — € '
- ‡ " ‡ > - ‡ — _ — † € † — € '
- - ' _ - - - - . † € † - ‡ " - >
' ' " , ' † > " — Pts—
† € — - - ' _ - - -

Орчин үеийн философид хүний талаарх олон урсгал чиглэл байдаг. Тухайлбал, амьдралын философи, экзистенциализм (оршихуйн философи), феноменологи, структурализм (бүтэц шинжлэлийн философи), психоаналитик (сэтгэц задлагийн философи) зэрэг олон дэг сургуулийг дурдаж болно.

Хүн бол бурхан, хувь заяа, байгалийн жам ёсонд даатгагдсан амьтан бус, харин сонголтын өмнө эрх чөлөөтэй, өөрийнхөө амьдралын утга учрыг өөрөө олж авдаг оршихуй мөн гэсэн үзэл санаа орчин үеийн философийн ихэнх урсгал чиглэлд нийтлэг байдаг.

Амьдралын философи

Амьдралын философи нь амьдралын утга, зорилго болон ёс зүйн талаарх уламжлалт сэтгэлгээг шүүмжилж гарч ирсэн чиглэл юм. Гол төлөөлөгч нь Ф.Ницше (1844-1900), А.Шопенгауэр (1788-1860) нар юм. Гол бүтээл нь Ф.Ницше “Зарастустра ийн өгүүлэв”, “Нүгэл буяны чанадад”, А.Шопенгауэр “Ертөнц нь хүсэл ба төсөөлөл болох нь” зэрэг болно.



ардчиллын зорилго мөн. Ингэснээр хүн өөрөө өөрийнхөө

өмнө хариуцдага хүлээх болдог.

Экзистенциалист философи

Экзистенциализм нь Би-гийн оршихуйн XX зууны философийн урсгал чиглэл юм. Гол төлөөлөгч нь С.Кьеркегор, А.Камю, Ж.П.Сартр нар. Экзистенциализмд хүн байхын утга учир бол тодорхой зорилготой байж, ёс суртахуунаа гээлгүй бусдын төлөө санаа зовинож, бусдыг өөр шигээ хайрлахад оршино хэмээн үздэг. С.Кьеркегор хүн өөрийгөө танин мэдэхэд шинжлэх ухааны арга хэрэг болдоггүй гэж үзээд тэрээр биет ахуй бол хүний жинхэнэ оршихуй биш бөгөөд экзистенцийг олж авах нь гадаад орчноор нөхцөлдөгч гадаад ахуйг мэдрэн хүртэх байдал биш, харин үл давтагдагч, орь ганц өөрийгөө олж авахуй мөн гэжээ.




Орчин үеийн Жан-Поль Сартр нийгэмд хүний энэхүү сонголтын эрх чөлөө хангагдах учиртай. Ийм боломжийг ардчилсан нийгэм олгодог.

Психоаналитик философи ба структурализм

Психоаналитик болон структурализм нь орчин үеийн шинжлэх ухаан, техникийн хурдацтай хөгжилд хүнийг аль

Орчлон ертөнцийн тухай хүмүүний ухаарлын дүр зураг

хэдийн бүрэлдэж тогтсон атъян хэлгээн үзэх болж хун өөрөө өөрийн бүтээсэн техникээс ялгаагүй, нийгэмт, төр, эдийн засаг, улс төрийн бодит байдлын эрэг шураг, багаж хэрэгсэл төдий болсон байна. Ийлгээс XX зууны хуний тухай философид техникжсэн, өөрөөсөө холдсон хунийг буцааж хун болгох зорилго хурцаар тавигдах болсон ют. Энэ ууднээс структурализлг ба психоаналитик философи нь хун төрөлхтний ухатсаргүй эхлэл руу тухайлбал зууд, домог гэх тэт балар эртний хутуусийн соёл руу хандаж, ташин хунийг хутууллэг хун байхад туслах сэтгэлгээний бүтцийг судалж шинжлэх болжээ. Гол төлөөлөгч нь З.Фрейд, К.Юнг нар ют. Фрейдийн “Онгон шүтлэг ба хорио цээр”, “Зуудний тайлал”, Юнгийн “Бэлгэдэлт алгьдрал” зэрэг бүтээлуудийг тонгол хэлээр орчуулсан.



Ертөнцийн тухай ямар ч дүр зураг орчлон хорвоогийн олон талт бодит байдлыг хэзээ ч бүрэн илэрхийлдэггүй, харин хүмүүний танин мэдэхүйн хөгжил, ухаарлын

хүрсэн төвшинд хийгдсэн оюун санааны зураглал байдаг. Ертөнцийн тухай дүр зураг хувь хүний төвшинд бол хүний «хөрөг», түүний орчлон ертөнцийг хэрхэн үзэхээс шалтгаалсан өөрөө өөртөө болон орчлон хорвоогийн

Орчлон ертөнцийн тухай хүмүүний ухаарлын дүр зураг

аливаа асуудалд хандах хандлага байдаг.

Ертөнцийн тухай хүмүүний ухаарлын дүр зураг өөрчлөгдөж солигдох үйл явц нь хүнийг өөрийнхөө болон ертөнцийн мөн чанарыг ойлгоход дөхөм болдог, танин мэдэхүйн жам ёсны шинжтэй үйл ажиллагаа юм. Хүн бодит байдлыг сэтгэлгээний янз бүрийн арга замаар таньж мэдэж, ойлгодог болохыг бид авч үзлээ.

Гэхдээ сэтгэлгээний эдгээр төрөл хэлбэрүүд нь бие биенээ нөхөн гүйцээж хүний амьдрал, үйл ажиллагаанд эн тэнцүү үүрэг гүйцэтгэдэг. философийн мэдлэг нь аль нэгэн агшин, тодорхой цаг үед шинжлэх ухаан, шашны дэвшүүлж байгаа ертөнцийн тухай дүр зургийг хамгийн төгс тогөлдөр эцсийн үнэн хэмээн дутуу бодож туушшрахаас ямагт урьдчилан сэргийлэх билээ.

Орчин үед шинжлэх ухааны аливаа мэддэг дангаараа асуудлыг шийдэх боломж хязгаарлагдмал болж харин шинжлэх ухааны олон салбар, шашин, соёлын хэлбэрүүд нэгдэн нийлж асуудлыг цогцоор нь тал бүрээс нь шийдвэрлэдэг шинэ хандлага руу орж байгааг эрдэмтэн судлаачид хүлээн зөвшөөрч байна.

Өөрөөр хэлбэл, зөвхөн байгалийн шинжлэх ухааны дангаараа шийдвэрлэж чадахгүй асуудлын шийдлийг философи, урлаг, шашин зэрэг сэтгэлгээний төрлүүд олж харах бололцоотой байж болох юм.

Орчлон ертөнцийн тухай хутуний ухаарлын дүр зураг

НОМ ЗҮЙ

1. Билл Брайсон. Шинжлэх ухааны товч түүх (Бараг бүх юмны тухай шастир)-1,11. Орч. Баабар. Т.Ариунсанаа. УБ., 2013.
2. Ц. Гомбосүрэн. Философи сурах бичиг. УБ., 2008.
3. Б. Даш-Ёндон. Нийгмийг танихуй:Түүх-хөгжлийн философи. Ред. Г.Чулуунбаатар. УБ., 2014.
4. С. Дулам. Монгол бэлгэдэл зүй. I боть. УБ., 2007.
5. С. Дулам. Монгол домог зүйн дүр. УБ., 2009.
6. Ертөнцийн шинжлэх ухааны дүр зургийн өөрчлөлт ба философи” сэдэвт симпозиумын илтгэлийн эмхтгэл. ШУА, ФСЭХ. УБ., 2014.
7. Г. Лодой. Шинжлэх ухааны судалгааны логик-арга зүйн асуудлууд. УБ., 2012.
8. Г. Лувсанцэрэн. Буддын гүн ухааны онол, түүхийн асуудлаас. УБ., 2008.
- Э.Майдрын эрин: Нийгмийн хөгжлийн чигхандлага. Эрдэм шинжилгээний бага хурлын илтгэлийн эмхтгэл. УБ., 2013.
- Ю.Монгол дахь иргэний нийгмийн төлөвшил сэдэвт эрдэм шинжилгээний бага хурлын эмхтгэл. УБ., 2013. П.Философи, шашин судлал, XII, №354, МУИС, УБ., 2011.
12. Философи, эрх зүйн боловсрол. Эрдэм шинжилгээний бичиг. 2012. №5.
13. Философи. Агуу сэтгэмжүүдийг энгийнээр тайлбарлах нь. Орч. Б.Батчулуун. УБ., 2012.
14. Стефен В.Хокинг. Цаг хугацааны товч түүх. Их тэсрэлтээс хар нүх хүртэл. Орч. Д.Нямсүрэн. УБ., 2010.
15. С.Соёлмаа. Домгийн бүтэц-тэмдэг зүйн үүднээс шинжлэх нь. (Монгол аман зохиолын жишээн дээр). Докторын диссертаци. УБ., 2014.
16. Ж.Гаардер. Софийн ертөнц. Орч. Б.Мөнхжавхлан. УБ.,2014.